



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 14

Турт

┌ Тогтоолд өөрчлөлт оруулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.8, 18.2 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28.1.3 заалтуудыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ханх сумын Хороо багт орших Шар нуураас загас агнах, барихыг 2017 оны 03 дугаар сарын 22 ны өдрөөс эхлэн 2019 оны 3 дугаар сарын 22 хүртэл 2 жилийн хугацаатай хоригийг тавихыг зөвшөөрсүгэй.

2. Энэ хугацаанд Шар нуурын загасны үржлийн болон биологийн дүгнэлт мэргэжлийн байгууллагаар гаргуулж ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнаж үр дүн хэрэгжилтийг тооцож ажиллахыг БОХ-ын улсын байцаагч Н.Энхболд байгаль хамгаалагч Х.Хишигжаргал ТХГ-ын улсын байцаагч Ч.Хургаа нарт үүрэг болгосугай

3. Тогтоол өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2016 оны 03 дугаар сарын 22 ны өдрийн 09 тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга К.Одгэрэлд үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ДУЛАМХҮҮ